ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ ТӨҮГ-ЫН 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

**АУДИТЫН КОД: САГ-2020/19/СТА-ТӨҮГ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.


**Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг**
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер Д.Энхдалай**
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
**Ахлах аудитор И.Эрдэнэцэцэг**
Утас: 260512 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn
**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Ихмонгол хөлөг аудит” ХХК**
Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn



Улаанбаатар хот
2020 он

## Агуулга


1. Аудитын гэрчилгээ ..... 2
2. Аудитын тайлан ..... 4
   2.1. Оршил ..... 4
   2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 4
   2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 4
   2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 5
   2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 5
   2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 5
   2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 5
   2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 6
   2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 6
   2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 7
   2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 8
   2.12. Шилэн дансны мэдээлэл ..... 8
   2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ..... 8
   2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 8
3. Менежментийн захидал ..... 9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 12
   4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 12
   4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 14
   4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 15
   4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 16
   4.5 Аудит хийгдсэн зорилтот түвшний биелэлт ..... 17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 19


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| НББОУС | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/874
танай ____________-ны № ____________-т

ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ
БАЙГУУЛАМЖ ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Г.ГАНСҮХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0313SAG106.Docx

01 0010515б2 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Аудитын гол асуудал**

Шилжүүлэн ачилтын гэрээ байгуулаагүй, шилжүүлэн ачилтын 55.5 сая төгрөгийн авлагыг бусад байгууллагын орлогоор хааж бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.3.1-т "анхан шатны баримт бүрдүүлэх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Үүрэг, хариуцлага**

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
0019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0313SAG108.Docx

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирал Г.Гансүх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтмол байршуулж байх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хууль, дүрэм, журам, зааврын өөрчлөлтийг тусгах, нөөц сан байгуулах журмыг баталж мөрдөх, шатахуун нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулж, урьдчилгаа тооцоо үүсгэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Үйлдвэрийн газрын захирал санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 11–ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, үйлдвэрийн газрын захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Ихмонгол хөлөг Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх үүргийн хүрээнд төмөр замаар тээвэрлэн нийлүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг Монголын вагонцистерн болон автоцистернд шилжүүлэн ачих, хадгалах үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай явуулах, газрын тосны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цаашид тус байгууламжийн ашиглалтыг мэргэжлийн удирдлагаар хангахад оршино" гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ;
- Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хэмжээ;
- Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2019 оноос мөрдөж эхэлсэн;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж нээлттэй мэдээлэх;
- Засгийн газрын "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 2019 оны 276 тугаар тогтоолоор цалингийн зэрэглэл өөрчлөгдсөн.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа "Diamond 5.0" программ хангамж ашиглаж байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 22 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "Дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,301.3 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 13.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг 33.2 сая төгрөгөөр материаллаг түвшин тогтоосон нь тайлант оны суурь үзүүлэлтийн дүнгээс тооцсонтой холбоотой байна.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө, нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн өмнөх оноос 1,632.9 сая төгрөгөөр буюу 10.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,419.8 | 3,171.5 | 1,751.6 |
| Авлага | 6.5 | 115.8 | 109.3 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 131.1 | 170.3 | 39.2 |
| Урьдчилж төлсөн зардал тооцоо | 3.0 | 11.5 | 8.5 |
| Үндсэн хөрөнгө | 14,555.5 | 14,279.8 | (275.7) |
| **Нийт хөрөнгө** | 16,115.9 | 17,748.8 | 1,632.9 |
| Өр төлбөр | - | 13.7 | 13.7 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 16,115.9 | 17,735.1 | 1,619.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 16,115.9 | 17,748.8 | 1,632.9 |

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,751.6 сая төгрөгөөр өссөн нь арилжааны банкинд 2,497.4 сая төгрөгийг хугацаатай хадгаламжийн дансанд байршуулсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 109.3 сая төгрөгөөр өссөн нь Ай си ай си ХХК-аас авах 106.0 сая төгрөг, татварын байгууллагаас авах 3.3 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь багаж хэрэгсэл, бусад мате 39.2 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь 570.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл өссөн нь аудитын явцад 13.7 сая төгрөгийн алдааг дансны өглөг, татварын өглөгийн дансанд залруулж тайлагнаснаас шалтгаалсан байна.

Монгол зөвлөлтийн хувь нийлүүлсэн Улаанбаатар Төмөр зам нийгэмлэгт өгөх 7.1 сая, цалингийн 0.3 сая, татварын байгууллагад төлөх 6.3 сая нийт 13.7 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл байна.

## 2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны орлогын төлөвлөгөөг 1,920.0 сая төгрөг, зардлын төлөвлөгөөг 1,317.2 сая төгрөг, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 336.3 сая төгрөгөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь орлогын төлөвлөгөөг 3,240.1 сая төгрөг буюу 68.8 хувиар давуулан биелүүлсэн, урсгал зардалд 1,299.1 сая төгрөг буюу 18.1

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардалд 309.1 сая төгрөг буюу 29.4 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 22 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 27 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,772.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 197.6 сая төгрөгийн алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 61.0 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,513.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Авлагын дэлгэрэнгүй бүртгэлийн дүнг санхүүгийн тайлангийн дүнтэй тулгахад "Лекс Ойл" ХХК-ийн авлагыг 147.1 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Авлагын дэлгэрэнгүй бүртгэлд залруулсан.

2. Монгол зөвлөлтийн хувь нийлүүлсэн Улаанбаатар Төмөр зам нийгэмлэгээс худалдан авсан 44.8 сая төгрөгийн цахилгааны төлбөрийг тооцооны дансанд бичилт хийхгүйгээр шууд зардлаар бүртгэж, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3-т "бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Нягтлан бодох бүртгэлд залруулсан.

3. Үндсэн хөрөнгөнд сайжруулалт хийхтэй холбоотой 71.2 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа 6.5 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг капиталжуулаагүй, буцаан авалтаар бүртгэсэн байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5-д "үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Санхүү, татварын тайланд залруулсан.

4. ХХОАТ-ын хөнгөлөлтийг тайлант хугацааны эцэст давтан тооцоолоход 31 ажилтны нийт 0.3 сая төгрөгийн тохируулга хийгдээгүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Санхүү, татварын тайланд залруулсан.

5. Тайлант хугацаанд 6 иргэнээс нийт 3.2 сая төгрөгийн худалдан авалт хийхдээ 0.3 сая төгрөгийн ХХОАТ-ыг суутгаж шилжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-т "энэ хуулийн ...12.2, 13.1.2, 13.1.3, 13.1.4-т заасан орлогын дүнд 23.2.4-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

6. Петролиум продакшн ХХК-тай шилжүүлэн ачилтын гэрээ байгуулаагүй, шилжүүлэн ачилтын 55.5 сая төгрөгийн авлагыг Ай си ай си ХХК-ийн орлогоор хааж бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.3.1-т "анхан шатны баримт бүрдүүлэх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Шилжүүлэн ачилтын гэрээ, авлага өглөгийг дараагийн аудитаар авч үзэх нь шаардлагатай.

## 2.12. Шилэн дансны мэдээлэл

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

## 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд орших буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал*

*1.1. Илрүүлэлт:*

Тус байгууллагын 2016 оноос мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт, хууль, тушаал, зааврудын өөрчлөлтүүдийг оруулж шинэчлээгүй байна. Энэ нь НББОУС 8.14-т а) өөрчлөлтийг СТОУС-аар шаардсан,б)өөрчлөлт нь тухайн аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээнд ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдлын үзүүлэх үр нөлөөний талаар найдвартай бөгөөд илүү хамааралтай мэдээллээр хангах үр дүнг санхүүгийн тайланд бий болгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавартнийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.", 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах", санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

*1.2. Эрсдэл:*

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлог, стандарт, хууль, тушаал, заавартнийцэхгүй байх.

*1.3. Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт, хууль, тушаал, заавартхолбогдох өөрчлөлтүүдийг тусган шинэчилж мөрдөх.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

***2. Шилэн данстай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

Шилэн дансны цахим хуудсанд 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасан санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

*2.2. Эрсдэл:*

Хуулийн хэрэгжүүлж ажиллахгүй байх;

*2.3. Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтмол байршуулж хэвших, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах.

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

***3. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*3.1. Илрүүлэлт:*

Байгууллагын сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг 3 арилжааны банкинд гэрээ байгуулан хадгалуулсан байна. Энэ нь Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захиралтай байгуулсан контрактын 3.2.18-д дараах асуудлыг зөвхөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрлөөр шийдвэрлэх үүрэгтэй "Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байгуулах, 50,000,000.00 (тавин сая) төгрөг болон түүнээс дээш хэмжээний зээл авах, өөрт олгогдсон эрх хэмжээнээс хэтэрсэн аливаа асуудал" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийн хангагүй байна.

*3.2. Эрсдэл:*

Хууль, тогтоомж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан контрактыг мөрдөхгүй байх.

*3.3. Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нөөц сан байгуулах журмыг боловсруулан,батлуулж мөрдөх, Арилжааны банкыг сонгохдоо Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч байх.

*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

*4. Анхан шатны баримттай холбоотой асуудал*

*4.1. Илрүүлэлт:*

Анхан шатны бүрдэл дутуу нийт 15.8 сая төгрөгийн баримтаар шатахууныг олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*4.2. Эрсдэл:*

Хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*4.3. Өгсөн зөвлөмж:*

Шатахуун нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулж, урьдчилгаа тооцоо үүсгэх, шатахуун хэрэглэх албан тушаалтнуудад карт олгох зэрэг арга хэлбэрүүдээс сонгож, журам боловсруулан мөрдөж ажиллах

*4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | - | - |
| **Эргэлтийн хөрөнгө** | - | - |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 1,419,849,547.03 | 3,171,484,081.52 |
| Дансны авлага | - | 106,034,478.00 |
| Татвар, НДШ-ийн авлага | 6,461,367.31 | 9,720,179.41 |
| Бусад авлага | - | - |
| Бусад санхүүгийн хөрөнгө | - | - |
| Бараа материал | 131,092,213.79 | 170,314,096.50 |
| Урьдчилж төлсөн зардал тооцоо | 2,997,992.00 | 11,473,600.00 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | - | - |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | - | - |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **1,560,401,120.13** | **3,469,026,435.43** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | - | - |
| Үндсэн хөрөнгө | 13,060,454,103.04 | 12,837,745,981.81 |
| Биет бус хөрөнгө | 1,495,010,127.06 | 1,442,033,241.51 |
| Биологийн хөрөнгө | - | - |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | - | - |
| Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | - | - |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | - | - |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | - | - |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **14,555,464,230.10** | **14,279,779,223.32** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **16,115,865,350.23** | **17,748,805,658.75** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | - | - |
| **ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **Богино хугацаат өр төлбөр** | - | - |
| Дансны өглөг | - | 7,122,454.00 |
| Цалингийн өглөг | - | 282,338.68 |
| Татварын өр | - | 6,344,811.23 |
| НДШ-ийн өглөг | - | - |
| Богино хугацаат зээл | - | - |
| Хүүгийн өглөг | - | - |
| Ногдол ашгийн өглөг | - | - |
| Урьдчилж орсон орлого | - | - |
| Нөөц / өр төлбөр / | - | - |
| Бусад богино хугацаат өр төлбөр | - | - |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ( борлуулах бүлэг хөрөнгө )- нд хамаарах өр төлбөр | - | - |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **-** | **13,749,603.91** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | |
|---|---|---|
| **Урт хугацаат өр төлбөр** | - | - |
| Урт хугацаат зээл | - | - |
| Нөөц / өр төлбөр/ | - | - |
| Хойшлогдсон татварын өр | - | - |
| Бусад урт хугацаат өр төлбөр | - | - |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | - | - |
| **Өр төлбөрийн нийт дүн** | - | **13,749,603.91** |
| **Эздийн өмч** | - | - |
| Төрийн өмч | 15,362,339,049.32 | 15,362,339,049.32 |
| Хувийн өмч | - | - |
| Хувьцаат өр төлбөр | - | - |
| Халаасны хувьцаа | - | - |
| Нэмж төлөгдсөн капитал | - | - |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 282,110,305.92 | 282,110,305.92 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | - | - |
| Эздийн өмчийн бусад хэсэг | - | - |
| Хуримтлагдсан ашиг | 471,415,994.99 | 2,090,606,699.60 |
| **Эздийн өмчийн дүн** | **16,115,865,350.23** | **17,735,056,054.84** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **16,115,865,350.23** | **17,748,805,658.75** |

### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **Борлуулалтын орлого ( цэвэр )** | **2,102,529,846.38** | **3,098,352,100.01** |
| Борлуулалтын өртөг | - | - |
| **Нийт ашиг ( алдагдал )** | **2,102,529,846.38** | **3,098,352,100.01** |
| Түрээсийн орлого | - | - |
| Хүүгийн орлого | 23,824,637.49 | 135,408,678.60 |
| Ногдол ашгийн орлого | - | - |
| Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| Бусад орлого | 6,908,180.91 | 6,308,500.00 |
| Борлуулалт, маркетингийн зардал | - | - |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 1,006,804,174.15 | 1,277,523,267.04 |
| Санхүүгийн зардал | 3,636,363.64 | 240,000.00 |
| Бусад зардал | - | 7,084,900.00 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз ) | - | - |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз ) | - | (14,258,571.81) |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз ( гарз ) | - | - |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз ( гарз ) | - | - |
| Бусад ашиг ( алдагдал ) | (178,607,591.39) | - |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )** | **944,214,535.60** | **1,940,962,539.76** |
| Орлогын татварын зардал | 112,282,212.70 | 196,981,986.71 |
| **Татварын дараах ашиг ( алдагдал )** | **831,932,322.90** | **1,743,980,553.05** |
| **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал )** | **-** | **-** |
| **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )** | **831,932,322.90** | **1,743,980,553.05** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| Мөнгөн орлогын дүн (+) | 2,320,616,040.00 | 3,311,065,062.59 |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 2,315,498,281.00 | 3,309,126,660.00 |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | - |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | - | - |
| Буцаан авсан албан татвар | - | - |
| Татаас, санхүүжилтийн орлого | - | - |
| Бусад мөнгөн орлого | 5,117,759.00 | 1,938,402.59 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 878,960,365.37 | 1,260,929,122.31 |
| Ажилагсад төлсөн | 192,825,370.00 | 347,724,377.00 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 54,439,017.11 | 90,277,851.14 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 72,041,558.00 | 151,693,384.33 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 45,622,427.50 | 44,217,990.91 |
| Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 24,031,467.00 | 31,419,410.45 |
| Хүүний төлбөрт төлсөн | - | - |
| Татварын байгууллагад төлсөн | 349,033,137.76 | 535,600,750.71 |
| Даатгалын төлбөрт төлсөн | 265,275.00 | 297,360.00 |
| Бусад мөнгөн зарлага | 140,702,113.00 | 59,697,997.77 |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 1,441,655,674.63 | 2,050,135,940.28 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| Мөнгөн орлогын дүн (+) | 23,417,502.51 | 135,408,678.60 |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | - | - |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | - | - |
| Хүлээн авсан хүүний орлого | 23,417,502.51 | 135,408,678.60 |
| Хүлээн авсан ногдол ашиг | - | - |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 106,236,762.00 | 309,120,235.95 |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 57,236,762.00 | 302,630,235.95 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 49,000,000.00 | 6,490,000.00 |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | - | - |
| Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | - | - |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 82,819,259.49 | (173,711,557.35) |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| Мөнгөн орлогын дүн (+) | - | - |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| Төрөл бүрийн хандив | - | |
| Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг | - | - |
| Мөнгөн зарлагын дүн (-) | - | 124,789,848.44 |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | - | - |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | - | - |
| Хувьцаа буцаан худалдаж төлсөн | - | - |
| Төлсөн ногдол ашиг | - | 124,789,848.44 |
| Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал | - | - |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | (124,789,848.44) |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 1,358,836,415.14 | 1,751,634,534.49 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 61,013,131.89 | 1,419,849,547.03 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,419,849,547.03 | 3,171,484,081.52 |

### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 14,869,843,049.32 | 44,414,440.00 | (360,516,327.91) | 14,553,741,161.41 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - |
| Залруулсан үлдэгдэл | - | - | - | - |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - |
| Өмчид гаргасан өөрчлөлт | 492,496,000.00 | - | - | - |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал ) | - | - | 831,932,322.90 | 831,932,322.90 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | 237,695,865.92 | - | - |
| 2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 15,362,339,049.32 | 282,110,305.92 | 471,415,994.99 | 16,115,865,350.23 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - |
| Залруулсан үлдэгдэл | 15,362,339,049.32 | 282,110,305.92 | 471,415,994.99 | 16,115,865,350.23 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - |
| Өмчид гаргасан өөрчлөлт | - | - | - | - |
| Зарласан ногдол ашиг | - | - | (124,789,848.44) | (124,789,848.44) |
| Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал ) | - | - | 1,743,980,553.05 | 1,743,980,553.05 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - |
| 2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 15,362,339,049.32 | 282,110,305.92 | 2,090,606,699.60 | 17,735,056,054.84 |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 4.5 Аудит хийгдсэн зорилтот түвшний биелэлт

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих | 720,000,000.00 | 948,352,100.01 | 228,352,100.01 | 131.7 |
| Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах | 1,170,000,000.00 | 2,150,000,000.00 | 980,000,000.00 | 183.8 |
| Бусад орлого /харилцахын хүү г.м/ | 30,000,000.00 | 141,717,178.60 | 111,717,178.60 | 472.4 |
| **Орлогын дүн** | **1,920,000,000.00** | **3,240,069,278.61** | **1,320,069,278.61** | **168.8** |
| Цалин хөлс | 422,022,000.36 | 362,886,076.00 | (59,135,924.36) | 86.0 |
| Шагнал, урамшуулал | 50,000,000.00 | 48,460,728.89 | (1,539,271.11) | 96.9 |
| НДШ | 61,193,190.05 | 49,177,542.14 | (12,015,647.91) | 80.4 |
| Машин механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ | 21,000,000.00 | 73,475,413.85 | 52,475,413.85 | 349.9 |
| Цахилгааны зардал | 51,631,250.00 | 51,615,812.12 | (15,437.88) | 100.0 |
| Албан томилолтын | 4,809,300.00 | 4,807,891.00 | (1,409.00) | 100.0 |
| Баярын арга хэмжээний | 6,500,000.00 | 6,114,755.56 | (385,244.44) | 94.1 |
| Бичиг хэргийн зардал | 1,384,500.00 | 2,015,355.28 | 630,855.28 | 145.6 |
| Элэгдлийн зардал | 540,000,000.00 | 570,546,670.92 | 30,546,670.92 | 105.7 |
| Шуудан холбооны зардал | 5,520,000.00 | 5,675,735.10 | 155,735.10 | 102.8 |
| Шатахууны зардал | 19,317,760.00 | 18,168,858.53 | (1,148,901.47) | 94.1 |
| Аж ахуйн хэрэгцээний | 7,618,000.00 | 3,237,390.35 | (4,380,609.65) | 42.5 |
| Авто сэлбэгийн зардал | 5,200,000.00 | 5,074,033.19 | (125,966.81) | 97.6 |
| ТХ-ийн татвар, агаарын бохирдол, тэмдэгтийн хураамж | 1,000,000.00 | 700,727.00 | (299,273.00) | 70.1 |
| Зам арчлалтын төлбөр | 36,000,000.00 | 19,716,137.81 | (16,283,862.19) | 54.8 |
| Банк хоорондын бэлэн бус гүйлгээний шимтгэл | 98,000.00 | 64,900.00 | (33,100.00) | 66.2 |
| Газрын төлбөр | 502,600.00 | - | (502,600.00) | 0.0 |
| Хог хаягдлын хураамж | 320,000.00 | 320,000.00 | - | 100.0 |
| Цэвэр усны төлбөр | 1,152,000.00 | 1,470,345.55 | 318,345.55 | 127.6 |
| Гал хөдөлмөр хамгааллын зардал | 3,903,100.00 | 3,211,105.00 | (691,995.00) | 82.3 |
| Үл хөдлөх хөрөнгийн татвар | 9,600,000.00 | 9,357,422.12 | (242,577.88) | 97.5 |
| Аудитын зардал | 4,000,000.00 | - | (4,000,000.00) | 0.0 |
| Сургалтын зардал | 2,000,000.00 | 270,000.00 | (1,730,000.00) | 13.5 |
| Лабораторийн итгэмжлэл, тусгай зөвшөөрөлтэй холбоотой гарах зардал | 2,550,000.00 | 2,005,781.82 | (544,218.18) | 78.7 |
| Хөдөлмөрийн чадвар түр алдсан болон дотоод журмын дагуу олгогдох бусад тэтгэмжүүд | 4,000,000.00 | 4,877,368.84 | 877,368.84 | 121.9 |
| Харуул хамгаалалтын зардал | 33,600,000.00 | 28,418,181.85 | (5,181,818.15) | 84.6 |
| Бусад зардал /нийгмийн хариуцлагын хүрээнд хийх ажил гэх мэт/ | 9,600,000.00 | 7,020,000.00 | (2,580,000.00) | 73.1 |
| Магадлашгүй зардал 1% | 12,721,997.01 | 6,159,934.12 | (6,562,062.89) | 48.4 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | - | 14,258,571.81 | 14,258,571.81 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Зардлын нийт дүн** | **1,317,243,697.42** | **1,299,106,738.85** | **(18,136,958.57)** | **98.6** |
| Санхүүгийн программ авах | 5,000,000.00 | 6,490,000.00 | 1,490,000.00 | 129.8 |
| Байгууламжийн 2.2 км өргөн болон нарийн царигийн төмөр замын тахир болон суман шилжүүлэг дээр бетонон дэр хийх ажил | 60,000,000.00 | 53,064,833.86 | (6,935,166.14) | 88.4 |
| Хашааны торон хамгаалалт хийх ажил | 12,000,000.00 | 11,977,630.00 | (22,370.00) | 99.8 |
| Бага оврын ковш трактор авах | 49,000,000.00 | 47,999,760.00 | (1,000,240.00) | 98.0 |
| Шугам хоолой суллах нөөцийн далд сав суурилуулах /шугам хоолойн хамт/ | 35,000,000.00 | 34,525,000.00 | (475,000.00) | 98.6 |
| Авто гарааж авах | 10,000,000.00 | 10,000,000.00 | - | 100.0 |
| Царцах, булингартах температур болон шүүгдэх хэм тодорхойлох багаж авах | 40,000,000.00 | 37,900,000.00 | (2,100,000.00) | 94.8 |
| Автомашин авах /ажилчид зөөх/ | 35,000,000.00 | 31,000,000.00 | (4,000,000.00) | 88.6 |
| Албан тушаалын байр авах | 49,000,000.00 | 43,000,000.00 | (6,000,000.00) | 87.8 |
| Хяналтын камер шинэчлэн өргөтгөж сайжруулах | 5,000,000.00 | 4,976,000.00 | (24,000.00) | 99.5 |
| Албан контор, харуулын барилгын гадна талын засвар | 10,000,000.00 | 5,765,000.00 | (4,235,000.00) | 57.7 |
| Олон талт барилгын дотор засвар | 7,000,000.00 | 1,848,812.09 | (5,151,187.91) | 26.4 |
| Суурин компьютер авах | 8,800,000.00 | 7,959,200.00 | (840,800.00) | 90.4 |
| Агааржуулагч авах /эйр кондейшн/ | 3,600,000.00 | 3,600,000.00 | - | 100.0 |
| Авто гараажийн барилгад халаалт тавих | 5,000,000.00 | 4,975,000.00 | (25,000.00) | 99.5 |
| Сандал | 800,000.00 | 760,000.00 | (40,000.00) | 95.0 |
| Бичгийн шүүгээ | 500,000.00 | 815,000.00 | 315,000.00 | 163.0 |
| Бичгийн ширээ | 600,000.00 | 235,000.00 | (365,000.00) | 39.2 |
| Гар станц авав | - | 1,584,000.00 | 1,584,000.00 | |
| Архивын тавиур | - | 645,000.00 | 645,000.00 | |
| **Хөрөнгө оруулалтын нийт дүн** | **336,300,000.00** | **309,120,235.95** | **(29,408,764.05)** | 91.9 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

| Огноо: | Аудитын нэр: | Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2019.12.31 | | | САГ-2020/19/СТА-ТӨҮГ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ ТӨҮГ | | Сая төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| 1 | | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тус байгууллагын 2016 оноос мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинээр батлагдсан стандарт, хууль, тушаал, заавруудын өөрчлөлтүүдийг оруулж шинэчлээгүй байна. | - | Зөвлөмж өгөх | Захирал<br>Нягтлан бодогч | Г.Гансүх<br>Б.Дэлгэрдалай |
| 2 | Шилэн дансны цахим хуудсанд 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | - | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч | Б.Дэлгэрдалай |
| 3 | Байгууллагын сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг 3 арилжааны банканд захирал гэрээ байгуулан хадгалуулсан байна. | - | Зөвлөмж өгөх | Захирал<br>Нягтлан бодогч | Г.Гансүх<br>Б.Дэлгэрдалай |
| 4 | Анхан шатны баримтын бүрдэлт дутуу нийт 15.8 сая төгрөгийн шатахууныг олгосон байна. | 15.8 | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч | Б.Дэлгэрдалай |
| 5 | Тайлант хугацаанд 6 иргэнээс нийт 3.2 сая төгрөгийн худалдан авалт хийхдээ 0.3 сая төгрөгийн ХХОАТ-ыг суутгаж шилжүүлээгүй байна. | 0.3 | Төлбөрийн акт тогтоох | Нягтлан бодогч | Б.Дэлгэрдалай |
| 6 | Мон суль ХХК-ийн 5.5 сая төгрөгийн авлагыг Лекс Ойл ХХК-ийн орлогоор хааж бүртгэсэн байна. | 5.5 | Албан шаардлага өгөх | Нягтлан бодогч | Б.Дэлгэрдалай |
| 7 | Петролиум продакшн ХХК-тай шилжүүлэн ачилтын гэрээ байгуулаагүй, шилжүүлэн ачилтын 55.5 сая төгрөгийн авлагыг Ай си ай си ХХК-ийн орлогоор хааж бүртгэсэн байна. | 55.5 | Албан шаардлага өгөх | Нягтлан бодогч | Б.Дэлгэрдалай |
| | НИЙТ ДҮН | 2,574.4 | | | |

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

**АКТ**

2020 оны 03 дугаар сарын 25 № 02/85 Улаанбаатар хот

САГ-2020/19/СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цагалбарт хугацаанд хийсэн Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 6 иргэнээс нийт 3,223,700.00 төгрөгийн худалдан авалт хийхдээ 322,370.00 төгрөгийн ХХОАТ-ыг суутгаж шилжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-т "энэ хуулийн ...12.2, 13.1.2, 13.1.3, 13.1.4-т заасан орлогын дүнд 23.2.4-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-т "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/124 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмын 2 дугаар хавсралт" -ыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Суутгаагүй 322,370.00 /Гурван зуун хорин хоёр мянга гурван зуун далан мянга/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирал Г.Гансүх, ерөнхий нягтлан бодогч Б.Дэлгэрдалай нарт хариуцуулав.

**АКТЫГ**

**ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ: ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ С.ТУНГАЛАГ

**ЗӨВШӨӨРСӨН:**

ЗАХИРАЛ Г.ГАНСҮХ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ: Б.ДЭЛГЭРДАЛАЙ

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

\\10.10.10.20\Bichig_Kheree\Akt\2020\0323SAG2.Docx

01 001090190 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

**АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 03 дугаар сарын 25 № 02/188 САТ-2020/19/СТА-ТӨҮГ Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цагалбарт хугацаанд хийсэн Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Петролиум продакшн ХХК-тай ачилтын гэрээ байгуулаагүй, шилжүүлэн ачилтын 55,482,086.00 төгрөгийн авлагыг Ай си ай си ХХК-ийн орлогоор хааж бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.3.1-т "анхан шатны баримт бүрдүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/124 дүгээр тушаал гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Петролиум продакшн ХХК-тай шилжүүлэн ачилтын гэрээ байгуулах, байгууллага хоорондын өмнөөс тооцоог зөвшөөрөлгүй хааж бүртгэхгүй байх, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирал Г.Гансүх, ерөнхий нягтлан бодогч Б.Дэлгэрдалай нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ: ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ С.ТУНГАЛАГ

**ЗӨВШӨӨРСӨН:**

ЗАХИРАЛ Г.ГАНСҮХ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ: Б.ДЭЛГЭРДАЛАЙ

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

\\10.10.10.20\Bichig_Kheree\Alban Shaardlaga\2020\0323SAG4.Docx

001080526